

**Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
олон талт оролцогчдын уулзалтын тэмдэглэл**

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын албаны хамтран зохион байгуулсан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон талт оролцогчдын уулзалт 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 9 цаг 30 минутад Монголын уул уурхайн үндэсний асоциацийн хурлын танхимд болов.

Уулзалтад ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүдээс гадна, урилга өгсөн олон талт оролцогчдын төлөөлөл оролцов.

Олон талт уулзалтыг нээж Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал, ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүн Н.Алгаа нар товч үг хэлж нээв.

Олон талт чуулга уулзалтаар дараахь асуудлыг хэлэлцүүлэв:

1/Аудитын үйлчилгээг зохион байгуулах тухай ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонгийн мэдээлэл (Мэдээллийг бүрэн эхээр хавсаргав);

2/ОУИТБС-ын 2006 онд компаниудаас хүлээн авсан татвар, төлбөрийн Засгийн газрын тайлан гаргасан тухай Үндэсний татварын ерөнхий газрын Мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн Б.Батсайханы мэдээлэл;

3/Бороо гоулд компаниас 2006 онд Засгийн газарт төлсөн татвар, төлбөрийн тайлан гаргасан тухай тус компанийн Ганхөлөгийн танилцуулга (танилцуулга англи хэл дээр байгааг хавсаргав);

4/"Онон-Улз голынхон хөдөлгөөн" төрийн бус байгууллагын тэргүүн Ж.Отгонцэцэгийн Хэнтий, Дорнод аймагт ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор тус байгууллагын зүгээс зохион байгуулж байгаа ажлын тухай танилцуулга (Мэдээллийг хавсаргав);

5/ОУИТБС-ын ач холбогдол ба тулгамдаж буй асуудлуудын талаар "Уугуул хөдөлгөөн" төрийн бус байгууллагын тэргүүн Д.Даян мэдээлэл (Мэдээллийг хавсаргав)

Үндэсний татварын ерөнхий газрын мэргэжилтэн Б.Батсайхан мэдээлэлдээ сум, аймгийн түвшин ажиллаж байгаа татварын байцаагч, албад ирүүлж байгаа татвар, төлбөрийн мэдээгээ нийт дүнгээр ирүүлдэг нь аж ахуйн нэгж бүрээс авсан татвар, төлбөрийн мэдээг гаргах ажилд хүндрэл учруулж байгааг тэмдэглэв.

Бороо гоулд компанийн мэргэжилтэн Ганхөлөг хийсэн мэдээлэлдээ тус компани ОУИТБС-ыг эхнээс дэмжиж, хэрэгжүүлж байгаа тухай тэмдэглээд 2004 оноос хойш 2007 оны 8 дугаар сарын 31 хүртэл хугацаанд тус компаниас Засгийн газарт төлсөн татвар, төлбөрийн талаар ярив. Тус компани Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулж эхний 3 жилд орлогын албан татвар төлөхгүй,

дараагийн 3 жилд орлогын албан татвараа 50 хувиар төлөх гэрээтэй. Тэрээр тогтвортой байдлын гэрээнд төрийн бус байгууллагын шахалт, Засгийн газрын санаачлагаар өөрчлөлт орж 2007 оноос татвар төлөх нөхцөл, нөөцийн төлбөр 3 хувь байсныг 5 хувь болгосон тухай мэдээлэв. ОУИТБС-ын 2006 оны тайланг гаргаж өгсөн. 2007 оноос эхнээс тогтвортой байдлын нэмэлт, өөрчлөлт орсон гэрээний дагуу 27.3 тэрбум төгрөгийн татвар, төлбөр төллөө. Нийт дүнгээр 2004 оноос 62.3 тэрбум төгрөгийн татвар, төлбөр улсад төлсөн нь уул уурхайн салбартаа Эрдэнэтийн дараа орох үзүүлэлт гэв (Татвар, төлбөрийн төрөл, он оноор хавсралтад байгаа материалд байгаа болно). Энэ үед иргэний нийгмийн байгууллагууд Бороо гоулд компанийн тогтвортой байдлын гэрээ Засгийн газар, монголын талд ашиггүй гэрээ гэсэн шүүмжлэл их өрнөж байсан тул түүний эсрэг мэдээллээ их тодорхой хийснийг энд тэмдэглэе.

“Дацан трейд” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Тогтуур манай компани 1997 онд байгуулагдсан, Увс аймгийн Тариалан сум, Төв аймгийн Заамар суманд алтны шороон орд ашигладаг. 136 кг алт олборлож, 252 сая төгрөгийн татвар, нөөц ашигласны төлбөр 160.0 сая төгрөг, гэнэтийн ашгийн татвар 260 сая төгрөг төлсөн. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар алтанд ногдуулах хууль гарснаас хойш алдагдалтай ажиллаж байна. Аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулахын тулд арилжааны банкнаас зээл авдаг, 100.0 гаруй сая төгрөгийн зээл, зээлийн хүүний өртэй байна гээд энэ татварыг бүтээгдэхүүний өртөг, заардлаас тогтоох нь зүйтэй гэсэн санал хэлэв. Тэрээ дэлхийн зах зээл дээр алтны үнийн өсөлт 9.4 хувь байхад зэсийнх 90 гаруй хувиар өссөн байна гэв.

Бороо гоулд компанийн ажилтан Ганхөлөг оролцогчдоос асуусан орон нутагт үзүүлж байгаа дэмжлэгийг хэрхэн зохион байгуулж байгаа талаархи асуултанд компани нь орон нутагтай ажиллах албатай, орон нутгийн 2 суманд дэмжлэг үзүүлдэг, сум бүрт комисс ажилладаг, энэ комисст сумаас, компаниас, иргэдээс төлөөлөлтэй, тэд ажлаа төлөвлөдөг, хэрэгжүүлсэн ажлаа комисс үнэлээд, тайлагнаж, дараагийн ажлаа төлөвлөж ажилладаг гэв.

Дацан трейд ХХК-ийн ерөнхий нябо Тогтуур оролцогчдоос асуусан орон нутагт үзүүлж байгаа дэмжлэгийг хэрхэн зохион байгуулж байгаа талаархи асуултанд манай компани Увс аймгийн Тариалан суманд бага сургуулийн барилга барьж өгсөн, мөн Увс аймагт 10.0 сая төгрөг хандивласан, Төв аймгийн Заамар суманд ажилчдын орон сууц барьж өгсөн, Тосон заамар төрийн бус байгууллагатай хамтарч ажилладаг гэв.

Суутгалын татвар яаж тогтоодог, 68 хувийн татварын суурь үнэ 2600 төгрөгийн тухай асуултад Ганхөлөг хариулахдаа техникийн үйлчилгээний татвар 5 хувийг авдаггүй, Канадтай Монгол Улс давхар татварын гэрээтэй, ер манай улс 30-аад оронтой давхар татварын гэрээтэй, гэрээгүй орноос 20 хувийн суутгалын татвар авах ёстой, 1997 оноос 5 хувь гэж хэлэлцээрээр тогтоосон байдаг гэв. Хэлэлцээргүй бол 20 хувь авна гэв. Зэсийн 68 хувийг тогтоохдоо зах зээлийн үнээс 2600-г хасаад, хайлуулах, цэвэршүүлэх зардлыг бас хасаад татвар авдаг. Энэ нь зэсийн зах зээлийн үнэ 8000 байвал 5100-г хасаад үлдсэнээс татвар авна гэсэн үг гэж хариулав. Алтан дээр бол зах зээлийн үнээс 50 хасаад 68 хувийн татвар тогтоодог гэж тэрээр хэлэв.

ОУИТБС-ын олон талын оролцогчдод хандаж Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь ОУИТБС-ын олон улсын нарийн бичгийн дарга нарын газар Лондонгоос Ослод шилжиж, нээлтээ хийсэн тухай, ОУИТБС-ын урьдчилсан баталгаажуулалт болж 15 улсыг нэр дэвшигчээр зарлалаа, энд Монгол Улс орсон тухай, Норвег Улс ОУИТБС-д нэгдэж орохоо зарласнаар энэ санаачлага хөгжлөөр хоцрогдсон орнуудад хэрэгжиж байгааг хөгжингүй орон ч хэрэгжүүлэх болж байгаа тухай, энэ санаачлага нь төрийн ажиллах шинэ арга барил болж байгаа тухай мэдээлэв.

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа ОУИТБС-ын тайлан гаргах манай улсын маягт их өргөн хүрээг хамарсан, хэрэгтэй ч юм бий, хэрэггүй ч төлбөр бийг цэгцлэх саналаа хэлэв. Хариуцлагатай уул уурхай гэсэн санаачлага бас хэрэгжиж байгаа, энэ 8 зарчимтайн 1 нэг нь ОУИТБС юм гэв.

Мөн татварын хуулинд энэ маягтад заасан мэдээллийг нээлттэй байхаар заах зүйтэй гэсэн санал гарав.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр олон талт уулзалтыг хааж хэлэхдээ олон талт оролцогч нарын энэ удаагийн уулзалт амжилттай боллоо. Мэдээлэл бүр бидэнд ая холбогдолтой байлаа. Манай улс бол ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хуультай орон, Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-т заасан, энэ асуудлыг Сорос Норвегийн Ослод болсон олон улсын чуулган дээр зарласан. Одоо хэрэгжилтийн агуулга тал дээр анхаарая. Оролцогчоос шүүмжилж байгаа орон нутагт асуудал байгаа гэдэгтэй санал нэг байна. Цаашид оролцогч талууд үүндээр анхаарах хэрэгтэй. Аудитын асуудлыг болон маягт 1, 2, 3-ыг ажлын хэсгийн хурлаар авч хэлэлцэх болно. Цаашид ОУИТБС-ын зарчим, шалгуур төрийн ажлын арга болно гэсэн Н.Дорждарийн саналыг дэмжиж байна.

Уулзалт тавьсан зорилгоо биелүүлсэн учир үүгээр хаая гэв. Оролцогчдод талархал илэрхийлэв.

Товч тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны ажилтан

Т.Хүрэлчимэг

Танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Э.Сумъяа